



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.04.19 № 373

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Б.АРИУН-ЭРДЭНЭ ТАНАА

*Б. Ариун-Эрдэнэ*  
*Булган аймгийн засаг дарга*  
*2024.04.28*

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ТШЗ-ийн 83, ОНӨААТҮГ-ийн 7, 16 сум, 1 тосгоны ТТЗ-ийн 17 нийт 107 байгууллага аудитад хамрагдсан.

Эдгээр байгууллагуудаас 51 байгууллагад дүгнэлт гаргаж, 56 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Үүнээс: "Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК, "Цоожид" ӨЭМТ, "Эмийн цэцэглэн" ӨЭМТ зэрэг 3 байгууллагын санхүүгийн тайланд "Татгалзсан дүгнэлт" өгсөн.

Санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар илэрсэн нийт 2,107.8 сая төгрөгийн материаллаг зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын дүнгээс 1,154.4 сая төгрөгөөр давсан тул санхүүгийн тайлангийн үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

006020876

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн татварын орлогыг 46,166.9 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 27,654.7 сая төгрөгөөр тус тус орлого төлөвлөж, гүйцэтгэлээр татварын орлогыг 49,620.0 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 24,752.3 сая төгрөг буюу нийт 74,372.3 сая төгрөгөөр орлого төвлөрүүлжээ.

УИХ-ын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж Булган аймгийн суурь орлогыг 29,833.3 сая төгрөгөөр, суурь зарлагыг 40,756.2 сая төгрөгөөр, орон нутгийн төсөвт өгөх дэмжлэгийг 10.9 сая төгрөгөөр баталжээ.

### **Аудитын гол асуудал**

Азийн хөгжлийн банкны орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх МОН1907-2003 төслийн зээл 987.0 сая төгрөгийн, Азийн хөгжлийн банкны хот байгуулалтын салбарын МОН2301-2015 төслийн зээл 2,331.0 сая төгрөгийн, Азийн хөгжлийн банкны Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН3713-2019 төслийн зээл 11,628.8 сая төгрөг буюу нийт 14,946.8 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Урт хугацаат зээлийн өглөг өмнөх оноос 454.9 сая төгрөгөөр өссөн нь валютын ханшны үнийн өөрчлөлттэй холбоотой байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/02 тоот хуралдааны тогтоолоор аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгэм эдийн засгийн үндсэн салбаруудын бодлогыг тодорхойлсон 5 бүлэг 101 зорилтыг жигд ханган биелүүлсэн гэж үзэж биелэлтийг 90.5 хувиар дүгнэжээ.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.



Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



~~Б.ЭРДЭНЭ~~